

## МОНГОЛ ОРНЫ ХҮН АМЫН ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ГАЗАРЗҮЙН АСУУДЛУУД

**Цэдэв-Ишийн Отгонхүү, (MA), ШУА, Газарзүй, Геоэкологийн хүрээлэн, Нийгэм, эдийн засгийн газарзүйн салбарын дэд ажилтан**

**Сандагийн Энх-Амгалан, (Ph.D), ШУА, Газарзүй, Геоэкологийн хүрээлэн, Нийгэм, эдийн засгийн газарзүйн салбарын тэргүүлэх ажилтан**

**Мөнхбатын Баяржаргал, Магистрант, ШУА, Газарзүй, Геоэкологийн хүрээлэн, Нийгэм, эдийн засгийн газарзүйн салбарын дадлагажигч ажилтан**

### Хураангуй

Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний сүүлийн 30 жилийн хандлагаас харахад хөдөөнөөс хот руу, ялангуяа Улаанбаатар хот руу шилжин суурьших үйл явц харьцангуй өндөр хэвээр хадгалагдсаар байна. Үүний үр дүнд хүн амын байршил, нутагшилтад өөрчлөлт гарч, хотын бүс нутгийн ачааллыг ихэсгэх, хүн амын хэт төвлөрөл, орчны бохирдол, үйлдвэрлэл-нутаг дэвсгэрийн зохисгүй харьцаа, бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн ялгаатай байдал зэрэг нийгэм, эдийн засгийн олон хүчин зүйлст бодитойгоор нөлөөлөх боллоо. Тиймд энэхүү судалгааны ажлын үндсэн зорилго нь сүүлийн 30 жилийн Монгол орны хүн амын дотоод шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийх юм. Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлтүүдийн сүүлийн 30 жилийн явцыг харахад байгалийн гамшигт үзэгдэл тохиолдсон онуудын дараагийн онд (2000, 2004, 2010) хүн амын шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоо өсдөг ерөнхий зүй тогтол ажиглагдах бөгөөд хөдөөнөөс хот руу, ялангуяа Улаанбаатар хот руу шилжин суурьших үйл явц харьцангуй өндөр хэвээр хадгалагдсаар байна. Түүнчлэн аймаг, орон нутгаас шилжин явагчид болон Улаанбаатар хотод шилжин ирэгчдийн тоог харьцуулан харахад 1990-1999 онуудад эдгээр үзүүлэлтийн хоорондын зөрүү их байсан бөгөөд нийт аймаг, орон нутгаас шилжин явагчдын тоонд Улаанбаатар хотод шилжин ирэгчдийн эзлэх хувь бага байгаа нь тухайн үед хүн амын дотоод шилжих хөдөлгөөнд аймаг хоорондын шилжилт зонхилж байсныг илтгэж байна. Харин 2000-2009 онуудад эдгээр үзүүлэлтүүд бараг зөрүүгүй болж, эзлэх хувь нь 65.4-өөс дээш байсан нь энэ үеийг нийслэл хотод шилжин ирэгчдийн оргил үе гэж нэрлэж болохоор байна. Харин 2010-2019 онуудад Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг томоохон хотуудаас гадна аймгийн төв хотууд руу чиглэх урсгал нэмэгдсэн зүй тогтол ажиглагдаж байгаа бөгөөд уул уурхайн ашиглалтаас үүдсэн ажлын байрыг даган Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций, Гурвантэс зэрэг сумд руу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн эрчимжсэн хэдий ч түр зуурын шинжтэй байна.

**Түлхүүр үгс:** хүн амын дотоод шилжих хөдөлгөөн, хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн, аймаг, орон нутгаас шилжин явагчид, Улаанбаатарт шилжин ирэгчид

### Abstract

The trend of Mongolia's internal migration over the last 30 years shows that migration from rural to urban areas, especially to Ulaanbaatar, remains relatively high. As a result, population settlement and distribution were changed, affecting many social and economic factors, such as increasing congestion in urban areas, overcrowding, environmental pollution, inefficient industrial-territorial relations, and disparities in regional economic development. Therefore, the main purpose of this study is to analyze the main indicators of internal migration in Mongolia over the last 30 years. From the insights of the main indicators, the following years of natural disasters (2000, 2004, 2010) reveal a general pattern of an increasing migration rate, and migration from rural to urban areas, especially to the capital city still remain relatively high. In addition, a comparison of the number of migrants from aimags and rural areas and migrants to Ulaanbaatar showed that the gap between these indicators was large between 1990 and 1999, and the share of migrants from Ulaanbaatar to the total number of migrants from aimags and rural areas was low when inter-aimag migration was predominant. However, in 2000-2009, these indicators were almost the same, with a share of more than 65.4 percent, which can be called the peak of migrants in the capital city. But, in 2010-2019, in addition to large cities such as Ulaanbaatar, Darkhan, and Erdenet, an increased flow is expected to aimag centers, and although migration to Khanbogd, Tsogttsetsii, and Gurvantes soums in Umnugovi aimag has intensified due to mining-related jobs, it is of temporary nature.

**Key words:** internal population migration, rural-urban migration, migrants from aimag and rural areas, migrants to Ulaanbaatar

## 1. УДИРТГАЛ

### Үндэслэл

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын Засгийн газраас хот, хөдөөгийн хүн амын нутагшилт, суурьшлын харилцан уялдсан тогтолцоог бүрдүүлж, нутаг дэвсгэрийн тэнцвэрт хөгжлийг бий болгох, хот, тосгоны төлөвлөлтийг шинэчлэх замаар урт хугацаанд тогтвортой хөгжлийг хангах, хүн амын эрүүл, аюулгүй, тав тухтай аж төрөх төв сууринг байгуулах зэрэг бодлогын томоохон зорилтуудыг шийдвэрлэх асуудалд онцгой анхаарал хандуулж байна. Монгол Улс 1990-ээд оноос зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш хөдөө, орон нутагт бий болсон ажлын байрны хомсдол болон байгалийн гамшигт үзэгдлээс (ган, зуд) болж, амьжиргааны хэдэн малаа алдаж амьдрах аргагүй болсон малчдын хөдөөнөөс хот суурин газар руу чиглэсэн “Их нүүдэл” тасралтгүй үргэлжилсээр байна (Д.Базаргүр, 2007). Эдгээр шилжин ирэгчид манай орны төв хэсэгт буюу томоохон хот суурин, тэдгээрийн дагуул бүс нутгуудаар суурьшиж, хүн амын байршил, нутагшилтад өөрчлөлт оруулж, хотын бүс нутгийн ачааллыг ихэсгэх, хүн амын хэт төвлөрөл, орчны бохирдол, үйлдвэрлэл-нутаг дэвсгэрийн зохисгүй харьцаа, бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн ялгаатай байдал зэрэг нийгэм, эдийн засгийн олон хүчин зүйлст бодитойгоор нөлөөлөх боллоо (С.Энх-Амгалан, 2019). Үүний үр дүнд 2020 оны байдлаар хотын хүн амын тоо 2212.9 мянгад хүрч, хотжилтын түвшин 68.0 хувьтай байгаа нь 1990 онтой харьцуулахад хотын хүн амын тоо 1037.5 мянган хүн буюу 88.2 хувиар, хотжилтын түвшин 13.5 пунктээр тус тус өссөн байна (ҮСХ, 2021). Энэхүү хандлагыг ҮСХ-оос 2015 онд гаргасан Монгол Улсын хүн амын 2045 он хүртэлх хэтийн тооцоонд суурилан тооцож үзэхэд 2045 гэхэд Монгол Улсын нийт хүн амын тоо 5010.4 мянга, үүнээс Улаанбаатар хотын хүн ам 2868.7 мянга буюу нийт хүн амын 57.2 хувь болж, эрчимтэй нэмэгдэх зүй тогтолтой байна (М.Алтанбагана, 2022).

Хүн амын шилжих хөдөлгөөн нь улс орны нийгэм, эдийн засаг, хүн амын өсөлт, соёл, боловсрол болон эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж, иргэдийн амьжиргааны түвшин, нийгмийн халамж, хамгаалал, хот төлөвлөлт зэрэг бүхий л асуудалд эерэг, сөрөг үр дагавруудыг үзүүлж байдаг хүн амын газарзүйн хамгийн чухал судлагдахууны нэг

(В.Батцэнгэл, 2021) бөгөөд Монгол Улсын төрөөс иргэдийнхээ эх орныхоо өргөн уудам нутаг дэвсгэрийн хаана ч чөлөөтэй шилжих суурьших эрхийг хүндэтгэж, ажиллаж амьдрах газраа сонгох нөхцлийг бүрдүүлэх, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаатай байдлыг аажмаар арилган жигдрүүлэх зорилгоор нийгэм, эдийн засгийн бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байгаа хэдий ч дэд бүтэц, мэдээлэл, харилцаа холбооны хөгжил, ажиллаж амьдрах таатай орчинд татагдан, чанартай боловсрол эзэмших, эрүүл мэндээ хамгаалуулах илүү боломжтой газар хайн төв суурин газар руу тэмүүлэх шилжих хөдөлгөөний урсгал буурахгүй хэвээр байна (ХАССТ, 2009, 2018). 1990-2019 оны нийт дүнгээр аймаг, орон нутгаас Улаанбаатар хотод нийтдээ 652.4 мян.хүн шилжин ирж, 197.9 мян.хүн шилжин явж, цэвэр шилжилт 454.5 мян.хүн болж байгаа бөгөөд 1990-2019 онуудын нийт шилжин ирэгчид 2019 оны Улаанбаатар хотын нийт хүн амын 44.5 хувьтай тэнцэж байна.

Манай улсад хүн амын шилжих хөдөлгөөний шалтгаан, шилжигчдийн шинж байдал, үр дагавар, чиг хандлагыг тодорхойлсон судалгаанууд (ХАССТ, 2001, 2004), (Ж.Оюунгэрэл, 2004), (ХАССТ, 2009, 2018) цөөнгүй хийгдсэн бөгөөд хүн амын шилжих хөдөлгөөнд нөлөөлж буй хүчин зүйлсийг нийгэм, эдийн засгийн болон байгалийн гэж ангилжээ (ХАССТ, 2018) (Ж.Оюунгэрэл, 2004). Эдгээр судалгаануудыг дүгнэж үзвэл хүн амын шилжих хөдөлгөөнд нөлөөлж буй нийгмийн (ажилгүйдэл, ядуурал), эдийн засгийн (ажлын байрны хомсдол, дэд бүтцийн хангамж, зах зээлийн боломж, үнийн зөрөө), байгалийн (уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшиг, усан хангамж, бэлчээрийн доройтол, уул уурхайн ашиглалт) зэрэг үндсэн шалтгаанууд байна. Хүн амын дотоод шилжих хөдөлгөөнд эдгээр хүчин зүйлс голчлон нөлөөлдөг хэдий ч байгалийн бүс, бүслүүр, хот, хөдөөгөөр харилцан адилгүй байгааг нутаг дэвсгэр, орон зайн тархалтын хувьд нарийвчлан судлах шаардлагатай байгаа юм. Түүнчлэн хүн амын шилжих хөдөлгөөний нөлөөгөөр улс орны хүн амын байршил, нягтшил, нутагшилтад ихээхэн өөрчлөлт гардаг (Ж.Оюунгэрэл, 2004) (ХАССТ, 2009, 2018) боловч үүнийг хөндсөн судалгаа бараг хийгдээгүй байна.

Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоог бүрдүүлэхэд нөлөөлөх үндсэн хүчин зүйлсийн нэг нь хүн амын шилжих

хөдөлгөөн бөгөөд Монгол Улсын Засгийн газраас Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий тогтолцоо хөтөлбөрийг боловсруулж байгаа энэ үед хүн амын дотоод шилжих хөдөлгөөний газарзүйн асуудлуудыг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах нь чухал юм.

## 1.2. Судалгааны ажлын зорилго

Энэхүү судалгааны ажлын зорилго нь сүүлийн 30 жилийн Монгол орны хүн амын шилжих дотоод хөдөлгөөний үндсэн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөхөд оршино.

## 1.3. Сэдвийн судлагдсан байдал

Монгол орны хүн амын шилжих хөдөлгөөний чиглэлээр хийгдсэн судалгаануудыг тоймлоход ШУА-ийн Газарзүйн хүрээлэн (хуучин нэрээр)-ийн Нийгэм, эдийн засгийн газарзүйн салбарын эрдэмтэн, судлаачид чухал үүрэг гүйцэтгэж иржээ. Тухайлбал: Академич Б.Гунгаадаш (1963, 1986) тус улсын хүн амын тоо, насны бүтэц, нутагшилтын өөрчлөлтөд задлан шинжилгээ хийж, хөдөлмөрийн нөөцийн хуваарилалт, өөрчлөлтөд хүн амын нөхөн үйлдвэрлэлийн хурдац шууд нөлөөлөхөөс гадна үйлдвэрлэх хүчний хөгжил, байршил, хүн амын шилжих хөдөлгөөн чухал үүрэгтэй гэж дүгнэжээ. Профессор М.Баянтөр (1971, 1995) хүн амын шилжих хөдөлгөөнийг хот суурингийн хөгжилтэй холбон авч үзсэн бөгөөд хүн амын шилжих хөдөлгөөний эрчим, шилжин ирэгчдийн суурьшил хот суурингийн хөгжилд ихээхэн нөлөө үзүүлж байна гэж дүгнэсэн нь хүн амын шилжих хөдөлгөөний үр дүн нь түүний нутагшилт, байршлаар илэрхийлэгдэнэ гэсэн санааг агуулж байна. Газарзүйч О.Сүхбаатар (1973) Монгол орны хүн амын шилжих хөдөлгөөнийг цэгцтэй судлах анхны оролдлогыг хийсэн бөгөөд “БНМАУ-ын хүн амын шилжих хөдөлгөөн” бүтээл туурвижээ. Доктор Ж.Оюунгэрэл (2005) “Нийгэм, эдийн засгийн шинэ нөхцөл дэхь Монгол орны хүн амын шилжих хөдөлгөөний газарзүйн асуудлууд”-ыг нарийвчлан судалж, шилжих хөдөлгөөнд нөлөөлөх хүчин зүйлсийг нийгэм, эдийн засаг, экологийн гэж ангилан шилжих хөдөлгөөний нутаг дэвсгэрийн ялгааг тодорхойлжээ. 1999 оноос Нийгэм, эдийн засгийн газарзүйн салбар болон өргөжиж, түүний бүрэлдэхүүнд Бүс нутгийн хөгжлийн төв, Нүүдэлч малчдын судалгааны төв, Газарзүйн нэр судлал, Зурагзүйн төв тус тус байгуулагджээ. Түүнээс хойш тус

салбарын хамт олон “Монгол орны хүн амын нутагшилт, хотжилтын орчин үеийн асуудал” 2005-2007, “Монгол Улсын нийгэм, эдийн засгийг тэнхлэгээр хөгжүүлэх газарзүйн үндэслэл” 2008-2010, “Монгол орны төв бүсийн нийгэм, эдийн засгийн газарзүйн иж бүрэн тодорхойлолт” 2011-2013 “Хүн амын нутагшилт, суурьшлын орон зайн зүй тогтол” 2014-2016, “Хөдөөгийн хүн амын суурьших үйл явцын газарзүйн судалгаа” 2017-2019, “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн онолын үндэс, нэгдсэн аргагүй, аргачлалыг шинэчлэн боловсруулах” 2019-2021 зэрэг суурь судалгааны төслүүдийг хэрэгжүүлжээ. Эдгээр төслүүдийн хүрээнд хүн амын дотоод шилжих хөдөлгөөний газарзүйн асуудлуудыг ямар нэг хэмжээгээр судалсан хэдий ч үүнийг улсын хэмжээнд, 1990-2020 онуудаар тодорхойлсон иж бүрэн судалгаа хийгдээгүй.

Монгол орны хүн амын дотоод шилжих хөдөлгөөн, шалтгаан, үр дагаврын чиглэлээр МУИС-ын харьяа Хүн амын сургалт, судалгааны төв (2001) “Дотоод шилжих хөдөлгөөний макро түвшний судалгаа” (2005) “Хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн” (2010) “Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чиг хандлага, үр дагавар” (2018) “Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний судалгаа” зэрэг цуврал судалгаануудыг Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хүн амын сан зэрэг олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр гүйцэтгэжээ. Тус судалгаануудын үр дүнд хүн амын шилжих хөдөлгөөний төлөв байдал, шилжих хөдөлгөөнд нөлөөлөх хүчин зүйлс, шилжигчдийн шинж байдал, үр дагавар, чиг хандлага зэргийг судалж, дүгнэлт, зөвлөмжүүдийг боловсруулсан байна. Үндэсний статистикийн хорооноос (2001), (2011) 2000 болон 2010 оны хүн ам, орон сууцны тооллогын материалд тулгуурлан Монгол Улсын хүн амын шилжих хөдөлгөөний үндсэн илтгэлүүдийг гаргажээ. Шилжих хөдөлгөөнийг 4 бүс нутаг ба Улаанбаатар хотоор ирэгчид, явагчид гэсэн шалгуур үзүүлэлтээр төрснөөс хойшхи, сүүлийн 5 жилийн болон 1 жилийн байдлаар хэмжиж, шилжих хөдөлгөөнд оролцогчдыг нас, хүйс, боловсролын байдлаар нь ялгажээ. Мөн шилжих хөдөлгөөнд оролцож буй шалтгаан шилжигчид тохиолдож буй бэрхшээл, шилжилтийн дараах өөрчлөлтүүд, ирээдүйн шилжилт ба шилжих хөдөлгөөний талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрт

дүн шинжилгээ хийсэн байна. Гэвч эдгээр судалгаанууд нь Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний орон зайн зүй тогтол, нутаг дэвсгэрийн ялгааг судлаагүй байна.

Монгол орны хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чиглэлээр хийгдсэн судалгаануудыг дүгнэж үзэхэд шилжих хөдөлгөөний төлөв байдал, хүчин зүйлс, шилжигчдийн шинж төлөв, тулгамдаж буй асуудлуудад дүн шинжилгээ хийсэн судалгаанууд цөөнгүй боловч шилжих хөдөлгөөний үр дагавар, орон зайн зүй тогтол, газарзүйн ялгаа, чиг хандлагыг тодорхойлсон судалгаа ховор байна.

## 2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

### 2.1. Судалгаанд ашигласан тоон өгөгдөл

Энэхүү судалгаанд Монгол Улсын хүн амын статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг 1990-2019 оноор буюу сүүлийн 30 жилийн өөрчлөлтөд дүн шинжилгээ хийсэн бөгөөд хүн амын шилжих хөдөлгөөн, байршил, нутагшилтын үндсэн үзүүлэлтүүдийн эх сурвалж нь Үндэсний статистикийн хорооноос 10 жил тутамд зохион байгуулдаг Хүн ам, орон сууцны тооллого болон суурин хүн амын жилийн эцсийн мэдээ, шилжин суурьшсан хүн амын тайлангууд юм. Шалгуур үзүүлэлтүүдийг Монгол Улсын статистикийн эмхэтгэл болон [www.1212.mn](http://www.1212.mn) статистик мэдээллийн сангаас аймаг, сумдын түвшинд 1990-1999, 2000-2009, 2010-2019 онуудаар цуглуулан MS Excel программ дээр анхан шатны боловсруулалтуудыг хийж, мэдээллийн сан үүсгэсэн. Сүүлийн 30 жилийн хугацааны Монгол орны хүн амын газарзүйн асуудлуудад дүн шинжилгээ хийхдээ 1990-1999, 2000-2009, 2010-2019 гэж үечилсэн нь дараах үндэслэлтэй.

1. Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлтүүдийн эх сурвалж болох Хүн ам, орон сууцны тооллого 2000, 2010, 2020 онуудад болсон.
2. Хүн амын, ялангуяа хөдөөгийн хүн амын шилжих хөдөлгөөнд нөлөөлдөг үндсэн хүчин зүйлсийн нэг болох байгалийн гамшиг (ган, зуд) 1999, 2009 онуудад тохиолдсон.

### 2.2. Судалгааны мэдээлэл боловсруулалт ба дүн шинжилгээ

Хүн амын шилжих хөдөлгөөн нь орон зай, цаг хугацааны хэмжээс бүхий, нийгэм, эдийн засаг, байгалийн нөхцөл, нөөцийн зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалах нийгэм, эдийн засгийн газарзүйн үйл явц бөгөөд түүний нутаг дэвсгэрийн онцлогийг илрүүлэхэд шилжин явагчид болон ирэгчид, шилжих хөдөлгөөний эрчим гэсэн үндсэн үзүүлэлтүүдийг ашигладаг (Ж.Оюунгэрэл, 2004). Хүн амын шилжих хөдөлгөөний хэмжээ буюу шилжигчдийн тоо гэдэг нь тухайн улс орон, муж нутагт шилжин ирэгсэд болон шилжин явагсдын тооны нийлбэрийг тодорхой хэсэгчилсэн хугацаанд (жил, сар) тооцсон үзүүлэлт юм. Харин шилжих хөдөлгөөний эрчим гэдэг нь тухайн улс орон, муж нутгийн 1000 буюу 10000 хүнд тодорхой хугацааны дотор явсан, ирсэн хүний тооны нийлбэрт харьцуулсан харьцаа юм. Шилжигсдийн зөрөө буюу цэвэр шилжилт гэж тодорхой хугацаанд улс орон, муж нутагт шилжин ирсэн, шилжин явсан хүн амын ялгаврыг хэлэх бөгөөд шилжин ирэгсдийн тоо шилжин явагчдын тооноос давж байвал цэвэр шилжин ирэлт, эсрэг тохиолдолд цэвэр шилжин явалт болдог (ХАССТ, 2006). Хүн амын шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлтүүдийг хүн амын нөлөөллийг арилгах зорилгоор 1000 хүнд харьцуулдаг бөгөөд тухайн жилд 1000 хүн тутамд ногдох шилжин ирсэн хүн амын тоог шилжин ирэлтийн коэффициент, 1000 хүн тутамд ногдох шилжин явсан хүн амын тоог шилжин явалтын коэффициент гэнэ. Харин шилжин ирсэн, шилжин явсан хүн амын тооны зөрүүг жилийн дундаж хүн амын тоонд харьцуулсан харьцааг шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент гэх бөгөөд доорх томъёонуудаар тооцдог (ҮСХ, 2013).

$$\text{ШХЭ} = \frac{\text{ШИ} + \text{ШЯ}}{\text{ХА}} * 1000 \quad (1)$$

Энд, ШХЭ – Шилжих хөдөлгөөний эрчим  
 ШИ – Шилжин ирсэн хүн амын тоо  
 ШЯ – Шилжин явсан хүн амын тоо  
 ХА – Хүн амын жилийн дундаж тоо

$$\text{ШИК} = \frac{\text{ШИ}}{\text{ХА}} * 1000 \quad (2)$$

Энд, ШИК – Шилжин ирэлтийн коэффициент  
 ШИ – Шилжин ирсэн хүн амын тоо  
 ХА – Хүн амын жилийн дундаж тоо



$$\text{ШЯК} = \frac{\text{ШЯ}}{\text{ХА}} * 1000 \quad (3)$$

Энд, ШЯК – Шилжин явалтын коэффициент  
 ШИ – Шилжин явсан хүн амын тоо  
 ХА – Хүн амын жилийн дундаж тоо

### 3. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

#### 3.1. Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний газарзүйн онцлог

Монгол Улсын шинэ үндсэн хуулинд зааснаар иргэд оршин амьдрах газраа чөлөөтэй сонгох эрхтэй болсноор өмнөх нийгмийн үед иргэдийн шилжих хөдөлгөөнийг захиргааны журмаар тогтоон барьж байсан нь өөрчлөгдөж, хүн амын шилжих үйл явц 1990-ээд оноос хойш улам эрчимжжээ. 1991-1992 онд хөдөөд нэгдэл, сангийн аж ахуйн өмч хувьчлал явагдаж, түүнээс хувь хүртэх сонирхолтой, “шинэ цагийн малчид” хотоос хөдөө шилжин суурьшиж байсан нь шилжин явалт давамгайлахад хүргэсэн. Гэвч энэ нь түр зуурын “хуурамч” шилжилт байв. 1992 оноос хойш шилжин явалт бүх нутагт давамгайлж, 1999 оноос шилжин ирэлт, явалт тэнцвэржих хандлагатай болсон (Ж.Оюунгэрэл, 2004) боловч 2000, 2004, 2010 зэрэг онуудад хүн амын шилжих хөдөлгөөн эрчимжсэн ерөнхий хандлагатай байна.

Монгол Улсын дүнгээр нийт шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоог сүүлийн 30 жилийн хугацаанд авч үзэхэд жилд дунджаар 95.3 мянган хүн шилжих хөдөлгөөнд оролцдог бөгөөд энэ үзүүлэлт 1990-1999 онд 97.3 мянган хүн, 2000-2009 онд 93.3 мянган хүн, 2010-2019 онд 95.4 мянган хүн байна. Харин жил бүрээр авч үзвэл 1990 онд 67.6 мян.хүн байснаа 1993 онд 136.9 мян.хүн болж өссөн хэдий ч түүнээс хойш тогтмол буурсаар 1999 онд 78.9 мян.хүн болжээ. 2000 онд 96.7 мян. хүн болж өссөн боловч 2001-2003 онуудад 76.3 – 85.2 мян.хүн хооронд хэлбэлзэж байснаа 2004 онд огцом өсч 115.7 мян.хүн болсон байна. 2005-2010 он хүртэл 81.5 -147.0 мян. хүн болтол өссөн нь оргил үзүүлэлт болжээ. Түүнээс хойш тогтвортой буурсаар 2019 онд 62.6 мян.хүн шилжих хөдөлгөөнд оролцсон байна. Шилжин ирэгчид болон явагчдад мөн адил зүй тогтол ажиглагдах бөгөөд 1990-1991 онд шилжин ирэгчид давамгайлж байсан бол 1993-2001 он хүртэл шилжин явагчид, 2002-2003 болон 2005-2008, 2010 онуудад шилжин ирэгчид бага зэрэг илүү байна. Харин 2011-2019 онуудад шилжин ирэгчид болон явагчдын тоо бараг тэнцүү болжээ (Зураг 3.1). Хүн амын шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлтүүдийн сүүлийн 30 жилийн явцыг харахад байгалийн гамшигт үзэгдэл тохиолдсон онуудын дараагийн онд (2000, 2004, 2010) хүн амын шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоо өсдөг ерөнхий зүй тогтол ажиглагдаж байна.

**Зураг 3.1. Хүн амын шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлтүүд, 1990-2019 он, улсын дүнгээр**



Эх сурвалж: ҮСХ, Статистик мэдээллийн нэгдсэн сан, www.1212.mn


Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний нутаг дэвсгэрийн онцлогийг илрүүлэхэд тухайн засаг захиргааны нэгжид шилжин ирэгч ба явагчийг хамтад нь авч үзэж, дүн шинжилгээ хийх нь тохиромжтой. 1990-2019 онуудад шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоог аймгуудаар авч үзвэл Улаанбаатар хот (850.3 мян.хүн), Төв аймаг (168.0 мян.хүн), Дархан-Уул аймаг (164.1 мян.хүн), Орхон аймаг (150.6 мян.хүн)-уудад хамгийн их, Говьсүмбэр аймаг (33.9 мян.хүн), Сүхбаатар аймаг (47.5 мян.хүн), Дундговь аймаг (56.3 мян.хүн)-уудад хамгийн бага үзүүлэлттэй байна. Харин эдгээр онуудаар хүн амын цэвэр шилжилтийг авч үзвэл зөвхөн Улаанбаатар хот (454.5 мян.хүн), Орхон аймаг (13.8 мян.хүн), Говьсүмбэр аймаг (0.6 мян.хүн) –ууд эерэг утгатай, Увс аймаг (-58.3), Баян-Өлгий аймаг (-50.9), Төв аймаг (-47.1) зэрэг 19 аймаг сөрөг утгатай буюу шилжин явалт давамгайлсан байна.

Шилжин ирэгчдийн тоо болон явагчдын тоог сүүлийн 30 жилийн дүнгээр аймгуудаар авч үзвэл ихээхэн ялгаатай байна. Тухайлбал: 1990-2019 онуудад шилжин ирэгчдийн тоог аймгуудаар харвал Улаанбаатар хот (652.4 мян.хүн), Орхон аймаг (82.2 мян.хүн), Дархан-Уул аймаг (76.3 мян.хүн), Сэлэнгэ аймаг (60.6 мян.хүн)-уудад хамгийн их, Сүхбаатар аймаг (17.0 мян.хүн), Говьсүмбэр аймаг (17.2 мян.

хүн), Дундговь аймаг (18.4 мян.хүн)-уудад хамгийн бага байна. Харин шилжин явагчдын тоо Улаанбаатар хот (197.9 мян.хүн), Төв аймаг (107.5 мян.хүн), Дархан-Уул аймаг (87.8 мян.хүн), Сэлэнгэ аймаг (81.0 мян.хүн)-уудад хамгийн их, Говьсүмбэр аймаг (16.7 мян.хүн), Сүхбаатар аймаг (30.5 мян.хүн), Өмнөговь аймаг (36.0 мян.хүн)-уудад хамгийн бага байна. Хүн амын шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлтүүдийг 1990-1999, 2000-2009, 2010-2019 онуудаар, аймгуудаар авч үзэхэд дараах онцлогууд ажиглагдаж байна.

**1990-1999 он:** 1990-1999 онуудад шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоог аймгуудаар авч үзвэл Улаанбаатар хот (167.9 мян.хүн), Баян-Өлгий аймаг (76.5 мян.хүн), Төв аймаг (59.1 мян.хүн), Хөвсгөл аймаг (51.5 мян.хүн)-уудад хамгийн их, Говьсүмбэр аймаг (10.9 мян.хүн), Сүхбаатар аймаг (18.4 мян.хүн), Дундговь аймаг (19.6 мян.хүн)-уудад хамгийн бага үзүүлэлттэй байна. Харин эдгээр онуудаар хүн амын цэвэр шилжилтийг авч үзвэл зөвхөн Улаанбаатар хот (77.0 мян.хүн), Орхон аймаг (17.2 мян.хүн), Булган аймаг (0.2 мян.хүн) – ууд эерэг утгатай, Баян-Өлгий аймаг (-31.2), Увс аймаг (-20.0), Дорнод аймаг (-18.1) зэрэг 19 аймаг сөрөг утгатай буюу шилжин явалт давамгайлсан байжээ (Хүснэгт 3.1, Зураг 3.1).

**Зураг 3.2. Хүн амын шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлтүүд, 1990-1999 он, аймгаар**



1990-1999 онуудад шилжин ирэгчдийн тоог аймгуудаар харвал Улаанбаатар хот (122.5 мян.хүн), Орхон аймаг (29.9 мян.хүн), Хөвсгөл аймаг (25.4 мян.хүн), Баян-Өлгий аймаг (22.7 мян.хүн)-уудад хамгийн их, Говьсүмбэр аймаг (5.4 мян.хүн), Сүхбаатар аймаг (8.7 мян.хүн), Дундговь аймаг (9.3 мян.хүн)-уудад хамгийн бага байжээ. Харин шилжин явагчдын тоо Баян-Өлгий аймаг (53.9 мян.хүн), Улаанбаатар хот (45.4 мян.хүн), Төв аймаг (37.4 мян.хүн), Увс аймаг (32.2 мян.хүн)-уудад хамгийн их, Говьсүмбэр аймаг (5.5 мян.хүн), Сүхбаатар аймаг (9.7 мян.хүн), Дундговь аймаг (10.3 мян.хүн)-уудад хамгийн бага байсан байна (Хүснэгт 3.1, Зураг 3.1).

1990-1999 оны дүнгээр авч үзэхэд шилжих хөдөлгөөний эрчим багатай буюу 1000 хүнд ногдох нийт шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоо 40 хүртэл аймгуудад Ховд аймаг (30.6), Сүхбаатар аймаг (33.0), Баянхонгор аймаг (33.4) зэрэг 5 аймаг, эрчим ихтэй буюу 60-аас дээш ангилалд Говьсүмбэр аймаг (101.6), Баян-Өлгий аймаг (89.0), Дорноговь (79.1) зэрэг 5 аймгууд багтаж байна.

**2000-2009 он:** 2000-2009 онуудад шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоог аймгуудаар авч үзвэл Улаанбаатар хот (339.4 мян.хүн), Төв аймаг (59.5 мян.хүн), Дархан-Уул аймаг (57.8 мян.хүн)-уудад хамгийн их, Говьсүмбэр аймаг (9.9 мян.хүн), Сүхбаатар аймаг (13.8 мян.хүн), Өмнөговь аймаг (14.9 мян.хүн)-уудад

хамгийн бага үзүүлэлттэй байна. Харин эдгээр онуудаар хүн амын цэвэр шилжилтийг авч үзвэл зөвхөн Улаанбаатар хот (246.4 мян.хүн), Орхон аймаг (1.7 мян.хүн), –т эерэг утгатай, Увс аймаг (-28.1), Төв аймаг (-25.8), Завхан аймаг (-23.9) зэрэг 20 аймагт сөрөг утгатай буюу шилжин явалт давамгайлсан байжээ. 2000-2009 онуудад шилжин ирэгчдийн тоог аймгуудаар харвал Улаанбаатар хот (292.9 мян.хүн), Дархан-Уул аймаг (27.0 мян.хүн), Орхон аймаг (26.5 мян.хүн)-уудад хамгийн их, Сүхбаатар аймаг (1.9 мян.хүн), Баян-Өлгий аймаг (2.4 мян.хүн), Дундговь аймаг (2.9 мян.хүн)-уудад хамгийн бага байжээ. Харин шилжин явагчдын тоо Улаанбаатар хот (46.5 мян.хүн), Төв аймаг (42.7 мян.хүн), Увс аймаг (31.7 мян.хүн)-уудад хамгийн их, Говьсүмбэр аймаг (5.1 мян.хүн), Өмнөговь аймаг (10.0 мян.хүн), Дорноговь аймаг (11.2 мян.хүн)-уудад хамгийн бага байсан байна (Хүснэгт 3.1, Зураг 3.2).

2000-2009 оны дүнгээр авч үзэхэд шилжих хөдөлгөөний эрчим багатай буюу 1000 хүнд ногдох нийт шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоо 40 хүртэл аймгуудад Баян-Өлгий аймаг (17.1), Хөвсгөл аймаг (20.5), Өвөрхангай аймаг (24.0) зэрэг 15 аймаг, эрчим ихтэй буюу 60-аас дээш ангилалд Говьсүмбэр аймаг (81.0), Төв аймаг (66.8), Дархан-Уул аймаг (65.3), Орхон аймаг (63.7) байна.


**Хүснэгт 3.1. Хүн амын шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлтүүд, 1990-2019 оноор, аймгаар**

№	Аймаг	Шилжин явагчид, мян.хүн				Шилжин ирэгчид, мян.хүн				Шилжих хөдөлгөөнд оролцогчид, мян.хүн				Зөрүү			
		1990	2000	2010	НИЙТ	1990	2000	2010	НИЙТ	1990	2000	2010	НИЙТ	1990	2000	2010	НИЙТ
1	Архангай	27,3	23,5	16,5	67,2	17,7	3,6	7,1	28,4	44,9	27,1	23,6	95,5	-9,6	-19,8	-9,4	-38,8
2	Баян-Өлгий	53,9	13,4	10,6	77,9	22,7	2,4	1,9	27,0	76,5	15,8	12,5	104,8	-31,2	-11,0	-8,7	-50,9
3	Баянхонгор	16,4	19,2	13,8	49,4	11,1	5,6	6,3	23,0	27,5	24,8	20,1	72,4	-5,3	-13,6	-7,4	-26,3
4	Булган	18,4	14,7	15,4	48,5	18,5	6,3	11,5	36,3	36,9	21,0	26,9	84,8	0,2	-8,4	-3,9	-12,1
5	Говь-Алтай	18,3	17,3	12,8	48,5	11,6	3,2	4,5	19,3	29,9	20,5	17,3	67,7	-6,8	-14,0	-8,4	-29,2
6	Говьсүмбэр	5,5	5,1	6,1	16,7	5,4	4,8	7,0	17,2	10,9	9,9	13,1	33,9	-0,1	-0,3	1,0	0,6
7	Дархан-Уул	25,9	30,8	31,1	87,8	22,6	27,0	26,7	76,3	48,5	57,8	57,9	164,1	-3,4	-3,7	-4,4	-11,5
8	Дорноговь	19,8	11,2	14,7	45,7	18,8	10,5	15,7	45,0	38,6	21,7	30,4	90,7	-1,0	-0,7	1,0	-0,7
9	Дорнод	29,6	18,3	13,4	61,4	11,6	4,8	8,3	24,6	41,2	23,1	21,7	86,0	-18,1	-13,6	-5,2	-36,8
10	Дундговь	10,3	15,2	12,4	37,9	9,3	2,9	6,3	18,4	19,6	18,1	18,7	56,3	-1,1	-12,3	-6,1	-19,5
11	Завхан	27,8	30,5	19,9	78,1	21,5	6,6	8,5	36,6	49,3	37,1	28,4	114,8	-6,2	-23,9	-11,4	-41,5
12	Орхон	12,6	24,8	31,0	68,4	29,9	26,5	25,8	82,2	42,5	51,3	56,8	150,6	17,2	1,7	-5,1	13,8
13	Өвөрхангай	18,7	20,1	21,6	60,4	17,6	5,7	7,8	31,1	36,4	25,7	29,4	91,5	-1,1	-14,4	-13,7	-29,2
14	Өмнөговь	15,4	10,0	10,5	36,0	11,0	4,9	14,8	30,8	26,4	14,9	25,4	66,7	-4,4	-5,1	4,3	-5,2
15	Сүхбаатар	9,7	11,9	8,9	30,5	8,7	1,9	6,4	17,0	18,4	13,8	15,3	47,5	-1,0	-10,1	-2,5	-13,5
16	Сэлэнгэ	24,3	27,3	29,4	81,0	17,6	16,2	26,8	60,6	41,9	43,4	56,2	141,5	-6,7	-11,1	-2,6	-20,4
17	Төв	37,4	42,7	27,5	107,5	21,7	16,9	21,9	60,5	59,1	59,5	49,4	168,0	-15,6	-25,8	-5,7	-47,1
18	Увс	32,2	31,7	16,7	80,6	12,2	3,6	6,5	22,3	44,3	35,3	23,2	102,8	-20,0	-28,1	-10,2	-58,3
19	Ховд	15,7	19,7	17,3	52,7	9,9	4,9	9,6	24,4	25,6	24,6	26,9	77,1	-5,8	-14,7	-7,7	-28,2
20	Хөвсгөл	26,1	19,0	18,0	63,1	25,4	5,0	9,0	39,4	51,5	24,0	27,0	102,5	-0,8	-13,9	-8,9	-23,6
21	Хэнтий	20,8	17,2	17,7	55,8	14,3	6,9	13,3	34,5	35,2	24,1	31,1	90,4	-6,5	-10,4	-4,4	-21,3
22	Улаанбаатар	45,4	46,5	106,0	197,9	122,5	292,9	237,0	652,4	167,9	339,4	343,0	850,3	77,0	246,4	131,1	454,5
23	<b>Улсын дүн</b>	<b>511,6</b>	<b>469,8</b>	<b>471,3</b>	<b>1452,7</b>	<b>461,5</b>	<b>463,1</b>	<b>482,8</b>	<b>1407,3</b>	<b>973,1</b>	<b>932,8</b>	<b>954,0</b>	<b>2860,0</b>	<b>-50,1</b>	<b>-6,7</b>	<b>11,5</b>	<b>-45,3</b>

Эх сурвалж: УСХ, Статистик мэдээллийн нэгдсэн сан, [www.1212.mn](http://www.1212.mn)




**Зураг 3.3. Хүн амын шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлтүүд, 2000-2009 он, аймгаар**



**2010-2019 он:** Сүүлийн 10 жилд шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоог аймгуудаар авч үзвэл Улаанбаатар хот (343.0 мян.хүн), Дархан-Уул аймаг (57.9 мян.хүн), Орхон аймаг (56.8 мян.хүн)-уудад хамгийн их, Баян-Өлгий аймаг (12.5 мян.хүн), Говьсүмбэр аймаг (13.1 мян.хүн), Сүхбаатар аймаг (15.3 мян.хүн)-уудад хамгийн бага үзүүлэлттэй байна. Харин эдгээр онуудаар хүн амын цэвэр шилжилтийг авч үзвэл зөвхөн Улаанбаатар хот (131.1 мян. хүн), Өмнөговь аймаг (4.3 мян.хүн), Дорноговь аймаг (1.0 мян.хүн), Говьсүмбэр аймаг (1.0 мян.хүн) –ууд эерэг утгатай, Өвөрхангай аймаг (-13.7), Завхан аймаг (-11.4) Увс аймаг (-10.2), зэрэг 18 аймаг сөрөг утгатай буюу шилжин

явалт давамгайлсан байна. 2010-2019 онуудад шилжин ирэгчдийн тоог аймгуудаар харвал Улаанбаатар хот (237.0 мян.хүн), Сэлэнгэ аймаг (26.8 мян.хүн), Дархан-Уул аймаг (26.7 мян.хүн)-уудад хамгийн их, Баян-Өлгий аймаг (1.9 мян.хүн), Говь-Алтай аймаг (4.5 мян.хүн), Дундговь аймаг (6.3 мян.хүн)-уудад хамгийн бага байжээ. Харин шилжин явагчдын тоо Улаанбаатар хот (106.0 мян.хүн) Дархан-Уул аймаг (31.1 мян.хүн), Орхон аймаг (31.0 мян.хүн)-уудад хамгийн их, Говьсүмбэр аймаг (6.1 мян.хүн), Сүхбаатар аймаг (8.9 мян.хүн), Өмнөговь аймаг (10.5 мян.хүн)-уудад хамгийн бага байсан байна (Хүснэгт 3.1, Зураг 3.3).

**Зураг 3.4. Хүн амын шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлтүүд, 2010-2019 он, аймгаар**




Сүүлийн 10 жилийн дүнгээр авч үзэхэд шилжих хөдөлгөөний эрчим багатай буюу 1000 хүнд ногдох нийт шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоо 40 хүртэл аймгуудад Баян-Өлгий аймаг (13.0), Хөвсгөл аймаг (21.7), Баянхонгор аймаг (24.5) зэрэг 13 аймаг, эрчим ихтэй буюу 60-аас дээш ангилалд Говьсүмбэр аймаг (83.7), Орхон аймаг (58.4), Дархан-Уул аймаг (57.8) зэрэг аймгууд багтаж байна.

Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний сүүлийн 30 жилийн хандлагаас харахад хөдөөнөөс хот руу, ялангуяа Улаанбаатар хот руу шилжин суурьших үйл явц харьцангуй өндөр хэвээр байсаар байна. 2000-2009 онуудад нийт шилжин ирэгчдийн 49.1 хувь буюу 237.0 мян.хүн зөвхөн Улаанбаатар хотод шилжин ирсэн нь 1990-2019 оны хооронд Улаанбаатар хотод шилжин ирэгчдийн 36.3 хувийг бүрдүүлж байна. Түүнчлэн 2000-аад оноос эхлэн Дархан, Эрдэнэт зэрэг томоохон хотууд болон төв тэнхлэгийн дагуух бүс нутгууд руу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн эрчимжсэн бөгөөд сүүлийн 10 жилд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг томоохон хотуудаас гадна аймгийн төв хотууд руу чиглэх урсгал нэмэгдсэн зүй тогтол ажиглагдаж байна. Уул уурхайн ашиглалтаас үүдсэн ажлын байрыг даган Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций, Гурвантэс зэрэг сумд руу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн эрчимжсэн хэдий ч түр зуурын шинжтэй байна.

### 3.2.Хэлэлцүүлэг

Сүүлийн 30 жилийн Монгол орны хүн амын шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлтүүдийн хандлагаас болон судалгааны үр дүнгүүдээс (ХАССТ, 2018); (A.Solongo, 2020); (Yecheng Xu et all, 2021) харахад хөдөө орон нутгаас томоохон хотууд, ялангуяа нийслэл Улаанбаатар хот руу шилжих хөдөлгөөний урсгал чиглэж байгаа хэдий ч дараах онцлогууд ажиглагдаж байна. Тухайлбал: 1990-2019 онуудаар аймаг, орон нутгаас шилжин явагчид болон нийслэл Улаанбаатар хотод шилжин ирэгчдийг харьцуулан авч үзэхэд 1990-1999 онуудад эдгээр үзүүлэлтүүдийн зөрүү нэлээд их, нийт аймаг, орон нутгаас шилжин явагчдын тоонд Улаанбаатар хотод шилжин ирэгчдийн эзлэх хувь 15.8 – 48.6 хувьтай байгаа нь тухайн үед хүн амын дотоод шилжих хөдөлгөөнд аймаг хоорондын шилжилт зонхилж байсныг илтгэж байна. Харин 2000-2009 оны хооронд эдгээр үзүүлэлтүүд хоорондоо бараг зөрүүгүй бөгөөд эзлэх хувь нь 30.9 – 107.6 хувьтай байгаа нь энэ үеийг Улаанбаатарт шилжин ирэгчдийн оргил үе гэж үзэх боломжтой байна. Түүнчлэн 2010-2019 онуудад эдгээр үзүүлэлтүүдийн зөрүү бага зэрэг нэмэгдсэн нь уул уурхайн ашиглалтаас үүдсэн Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сумд руу чиглэсэн ажиллах хүчний шилжилттэй холбоотой хэдий ч эзлэх хувь нь 28.0 – 86.5 хувьтай байгаа нь хөдөө, орон нутгаас хот суурин газар руу, ялангуяа нийслэл Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөний урсгал буурахгүй байгааг харуулж байна (Зураг 3.4).

**Зураг 3.5. Аймаг, орон нутгаас шилжин явагчид ба Улаанбаатарт шилжин ирэгчид, 1990-2019 он**



Эх сурвалж: ҮСХ, Статистик мэдээллийн нэгдсэн сан, www.1212.mn

#### 4. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэсээр дэвшүүлсэн зорилго, зорилтууддаа хүрсэн бөгөөд дараах байдлаар дүгнэж байна. Үүнд:

1. Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлтүүдийн сүүлийн 30 жилийн явцыг харахад байгалийн гамшигт үзэгдэл тохиолдсон онуудын дараагийн онд (2000, 2004, 2010) хүн амын шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоо өсдөг ерөнхий зүй тогтол ажиглагдах бөгөөд 1990-1999, 2000-2009, 2010-2019 гэж үечлэх нь Монгол орны хүн амын дотоод шилжих хөдөлгөөний газарзүйн онцлогийг илрүүлэхэд тохиромжтой байна.
2. Хөдөөнөөс хот руу, ялангуяа Улаанбаатар хот руу шилжин суурьших үйл явц харьцангуй өндөр хэвээр хадгалагдсаар байна. 2000-2009 онуудад нийт шилжин ирэгчдийн 49.1 хувь буюу 237.0 мян.хүн зөвхөн Улаанбаатар хотод шилжин ирсэн нь 1990-2019 оны хооронд Улаанбаатар хотод шилжин ирэгчдийн 36.3 хувийг бүрдүүлж байна. Тийм учраас 2000-2009 оныг Улаанбаатар хотод шилжин ирэгчдийн оргил үе гэж нэрлэж болохоор байна. Түүнчлэн 2000-аад оноос эхлэн хөдөө орон нутаг, зах хязгаар нутгуудаас томоохон хотууд болон төв тэнхлэгийн дагуух бүс нутгууд, ялангуяа Улаанбаатар хотод руу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн эрчимжсэн бөгөөд сүүлийн 10 жилд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг томоохон хотуудаас гадна аймгийн төв хотууд руу чиглэх урсгал нэмэгдсэн зүй тогтол ажиглагдаж байна. Уул уурхайн ашиглалтаас үүдсэн ажлын байрыг даган Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций, Гурвантэс зэрэг сумд руу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн эрчимжсэн хэдий ч түр зуурын шинжтэй байна.
3. Аймаг, орон нутгаас шилжин явагчид болон Улаанбаатар хотод шилжин ирэгчдийн тоог харьцуулан харахад 1990-1999 онуудад эдгээр үзүүлэлтийн хоорондын зөрүү их байсан бөгөөд нийт аймаг, орон нутгаас шилжин явагчдын тоонд Улаанбаатар хотод шилжин ирэгчдийн эзлэх хувь бага байгаа нь тухайн үед хүн амын дотоод шилжих хөдөлгөөнд аймаг хоорондын шилжилт зонхилж байсныг илтгэж байна. Харин

2000-2009 онуудад эдгээр үзүүлэлтүүд бараг зөрүүгүй болж, эзлэх хувь нь 65.4-өөс дээш байсан бол 2010-2019 онуудад бага зэрэг буурсан хандлага ажиглагдаж байна.

#### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

##### Монгол хэл дээр

- Б.Гунгаадаш (1986). *БНМАУ-ын нийгэм, эдийн засгийн газарзүй*
- В.Батцэнгэл (2021). *Хүмүүний газарзүй*. Улаанбаатар: МУИС, Хэвлэлийн газар
- В.Батцэнгэл, Р. Б (2021). *Хүмүүний газарзүй*. Улаанбаатар: МУИС, Хэвлэлийн газар
- Д.Базаргүр (2007). *Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэчлэлийн нийгэм, эдийн засгийн газарзүйн тандах судалгаа*. Улаанбаатар: Admon printing
- Ж.Оюунгэрэл (2004). *Нийгэм, эдийн засгийн шинэ нөхцөл дэх Монгол Улсын хүн амын шилжих хөдөлгөөний газарзүйн асуудлууд*. Улаанбаатар
- М.Алтанбагана (2022). *“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн онолын үндэс, нэгдсэн аргазүй, аргачлалыг шинэчлэн боловсруулах” суурь судалгааны төслийн тайлан*. Улаанбаатар
- М.Баянтөр (1971). *БНМАУ-ын хүн амын газарзүйн зарим асуудлууд*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар
- С.Энх-Амгалан (2019). *Хөдөөгийн хүн амын суурьших үйл явцын газарзүйн судалгаа*. Улаанбаатар
- ҮСХ (2013). *Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал*
- ҮСХ (2013). *Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал*. Улаанбаатар
- ҮСХ (2020). *Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн*. Улаанбаатар
- ҮСХ (2021). *Монгол Улсын статистикийн эмхэтгэл-2020*. Улаанбаатар
- ХАССТ (2001). *Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа*, Улаанбаатар

ХАССТ (2004). *Улаанбаатар хотын хүн амын ядуурал ба шилжих хөдөлгөөн, Улаанбаатар*

ХАССТ (2006). *Хүн ам зүйн үндсэн асуудлууд, Улаанбаатар*

ХАССТ (2009). *Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чиг хандлага, үр дагавар. Улаанбаатар; Бит пресс*

ХАССТ (2018). *Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний судалгаа. Улаанбаатар*

Цэдэнсодном, Х (2003). *Монголын хүн ам ба хүрээлэн буй орчин. Улаанбаатар*

### **Англи хэл дээр**

Solongo A (2020). Relationship between rural to urban migration and dzud disaster impact. *Mongolian population Journal, Scientific paper of National University of Mongolia* (470) 27, pp.78-84, ISSN-2226-1389, NUM Press printing, Ulaanbaatar

Yecheng Xu et al (2021). Migration under economic transition and changing climate in Mongolia. *Journal of Arid environments*, 185 (104333)